



Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230



Research Article

DOI: <https://doi.org/10.65816/jsds.2026.02.002>

Theoretical Contestations and Geoeconomic Implications of the Russia-Ukraine War

Tuvdendarjaa Munkh-Orgil

Colonel, Ph.D., Associate Professor, Director, Defense Research Institute of Mongolia

E-mail address: munkh-orgil@mids.gov.mn, ORCID: [0009-0001-9907-0011](https://orcid.org/0009-0001-9907-0011)

Received: 09 July 2026

Revised: 20 July 2026

Accepted: 23 July 2026

Published online: 28 July 2026



ABSTRACT

The Russia–Ukraine war, which began in 2022, has become a defining geopolitical event that has accelerated the transformation of the post-Cold War international order while reshaping the geopolitical and geoeconomic landscape of Eurasia. This article examines the causes, dynamics, and implications of the conflict through the theoretical perspectives of Kenneth Waltz’s structural neorealism, security dilemma theory, John J. Mearsheimer’s offensive realism, and Halford J. Mackinder’s Heartland Theory. The study employs qualitative comparative analysis, case study, and document analysis, drawing upon statistical data and policy reports published by the OECD, the World Bank, the European Commission, and the Trans-Caspian International Transport Route (TITR) for the period 2022–2025.

The findings indicate that the Russia–Ukraine war represents not only a military confrontation but also a profound geoeconomic transformation affecting Eurasian trade, energy networks, logistics systems, supply chains, and strategic transportation corridors. The decline of the Northern Corridor and the growing strategic significance of the Trans-Caspian International Transport Route (Middle Corridor) illustrate the reconfiguration of Eurasian connectivity. The study argues that the conflict reflects the ongoing transition toward a multipolar international order in which global influence is increasingly determined not only by military power but also by infrastructure connectivity, economic networks, supply chain resilience, and geoeconomic competitiveness.

Keywords: Russia–Ukraine War; Geopolitics; Structural Neorealism; Security Dilemma; Heartland Theory; Geoeconomics; Eurasian Connectivity; Middle Corridor.

Орос-Украины дайны талаарх онолын тайлбарын эсрэгцэл ба геоэдийн засгийн зарим асуудлууд

Түвдэндаржаа Мөнх-Оргил

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), дэд профессор, хурандаа, munkh-orgil@mids.gov.mn, ORCID: [0009-0001-9907-0011](https://orcid.org/0009-0001-9907-0011)

ХУРААНГУЙ

2022 онд эхэлсэн Орос-Украины дайн нь Хүйтэн дайны дараах олон улсын тогтолцооны

өөрчлөлтийг эрчимжүүлж, Евразийн геополитик, геоэдийн засгийн орчныг шинэ шатанд шилжүүлсэн үйл явдал болж байна. Энэхүү өгүүлэлд Орос-Украины дайны шалтгаан, өрнөл, үр дагаврыг олон улсын харилцааны онолын үндсэн хандлагууд болох Кеннет Валзийн бүтцийн неореализм, аюулгүй байдлын хоёрдмол байдлын онол, Жон Ж. Миршаймерын довтолгооны реализм болон Халфорд Жон Маккиндерын Зүрхэн газрын онолын хүрээнд харьцуулан шинжилсэн. Судалгаанд чанарын харьцуулсан шинжилгээ, кейс судалгаа, баримт бичгийн шинжилгээний аргыг ашиглаж, OECD, World Bank, European Commission, TITR зэрэг байгууллагын 2022-2025 оны мэдээлэл, статистикийг нэгтгэн үнэлэв.

Судалгааны үр дүнгээс үзэхэд энэхүү дайн нь зөвхөн цэрэг, улс төрийн мөргөлдөөн бус, Евразийн худалдаа, эрчим хүч, ложистик, нийлүүлэлтийн сүлжээ, тээврийн коридоруудын бүтцийг өөрчилсөн геоэдийн засгийн томоохон шилжилтийг бий болгожээ. Ялангуяа Хойд тээврийн коридорын ач холбогдол буурч, Транскастийн олон улсын тээврийн маршрут буюу Дунд коридорын стратегийн үнэ цэнэ эрчимтэй өсөн нэмэгдэж байна. Энэхүү өөрчлөлт нь олон улсын тогтолцоо олон төвт бүтэц рүү шилжиж буйг илэрхийлэхийн зэрэгцээ цэргийн хүчин чадалаас гадна эдийн засгийн холболт, дэд бүтэц, нийлүүлэлтийн сүлжээ болон геоэдийн засгийн сөрөн тэсвэрлэх чадвар стратегийн өрсөлдөөний үндсэн хэмжүүр болж байгааг харуулж байна.

Түлхүүр үг: Орос-Украины дайн; геополитик; бүтцийн неореализм, Зүрхэн газрын онол; геоэдийн засаг; Евразийн холболт; Дунд коридор.

Оршил

XXI зууны олон улсын харилцааны тогтолцоо нь Хүйтэн дайны дараах нэг туйлт бүтцээс аажмаар олон төвт, өрсөлдөөнт, стратегийн тодорхой бус байдал давамгайлсан шинэ орчин руу шилжиж байна. Энэхүү шилжилт нь зөвхөн дэлхийн хүчний тэнцвэрийн өөрчлөлтөөр хязгаарлагдахгүй бөгөөд аюулгүй байдлын ойлголтын хувьсал, олон улсын институцийн өрсөлдөөн, геополитикийн нөлөөллийн бүсийн дахин хуваарилалт, эдийн засгийн харилцан хамаарлын шинэ хэлбэрүүдээр илэрч байна. Өөрөөр хэлбэл, орчин үеийн олон улсын системд цэргийн хүчин чадал төдийгүй стратегийн байршил, технологийн давуу тал, нийлүүлэлтийн сүлжээ, эдийн засгийн холболт зэрэг геоэдийн засгийн хүчин зүйлс хүчний тэнцвэрийг тодорхойлох чухал элемент болж байна.

Энэхүү өөрчлөлтийн тод илрэлүүдийн нэг нь 2022 онд эхэлсэн Орос-Украины дайн бөгөөд уг мөргөлдөөн нь зөвхөн хоёр улсын хоорондын зэвсэгт сөргөлдөөн бус, харин Европын аюулгүй байдлын архитектур, Евразийн геостратегийн тэнцвэр, олон улсын тогтолцооны ирээдүйн чиг хандлагад нөлөөлж буй системийн шинжтэй үйл явдал болж байна. Орос-Украины дайны шалтгаан, динамикийг олон улсын харилцааны онолын хүрээнд авч үзэхэд харилцан адилгүй геополитикийн ойлголт, аюулгүй байдлын төсөөллийн зөрчилдөөн тодорхой харагддаг.

Барууны улс орнуудын байр сууринаас авч үзвэл НАТО-гийн өргөжилт нь Хүйтэн дайны дараах Европын тогтвортой байдлыг хангах, хамтын хамгаалалтын механизмыг бэхжүүлэх, улс орнуудын аюулгүй байдлын сонголтыг дэмжих институцийн үйл явц гэж тайлбарлагддаг. Харин ОХУ-ын стратегийн ойлголтоор НАТО-гийн зүүн тийш өргөжилт нь түүний уламжлалт аюулгүй байдлын орчинд барууны цэрэг-улс төрийн нөлөө ойртож буй үйл явц бөгөөд геостратегийн тэнцвэрт эрсдэл учруулж буй хүчин зүйл гэж үздэг. Энэхүү ялгаатай ойлголт нь олон улсын харилцаанд “аюулгүй байдлын хоёрдмол байдал” хэрхэн үүсч, улс орнуудын хамгаалалтын шинжтэй үйлдэл нөгөө талд нь заналхийлэл мэтээр хүлээн авагддагийг харуулж байна.

Энэ хүрээнд Украин нь зөвхөн бүс нутгийн нэг улс бус, Европын аюулгүй байдлын орон зай, Евразийн геостратегийн тэнцвэр, их гүрнүүдийн ашиг сонирхлын огтлолцлын цэг болсон стратегийн ач холбогдол бүхий орон зай юм. Тиймээс Орос-Украины дайныг зөвхөн хоёр улсын хоорондын улс төр, цэргийн маргаанаар хязгаарлан тайлбарлах боломжгүй бөгөөд цэргийн талбараас давсан үр дагавар бий болгож, олон улсын худалдаа, эрчим хүч, тээвэр, ложистик, хөрөнгө оруулалт, нийлүүлэлтийн сүлжээний бүтцэд томоохон өөрчлөлт авчирч байна.

Орос-Украины дайны талаар сүүлийн жилүүдэд олон тооны судалгаа хэвлэгдсэн боловч тэдгээрийн дийлэнх нь мөргөлдөөнийг дан ганц аюулгүй байдал, НАТО-гийн өргөжилт, эсвэл их гүрний өрсөлдөөний хүрээнд тайлбарласан байдаг. Харин дайнаас үүдэлтэй Евразийн геоэдийн засгийн дахин бүтэцжилт, тээврийн коридоруудын стратегийн өөрчлөлт болон эдгээр өөрчлөлтөөс жижиг, далайд гарцгүй орнуудын геостратегийн боломжид үзүүлэх нөлөөг олон улсын харилцааны онолуудыг уялдуулан тайлбарласан судалгаа харьцангуй хомс байна.

Иймээс энэхүү өгүүлэл нь Орос-Украины дайныг нэг талаас олон улсын харилцааны онолын өрсөлдөөнт тайлбаруудын хүрээнд, нөгөө талаас дайнаас үүдэлтэй геоэдийн засгийн өөрчлөлтүүдийн хүрээнд шинжлэхийг зорьж байна.

Энэхүү судалгааны өгүүлэл нь чанарын судалгааны харьцуулсан шинжилгээнд тулгуурласан болно. Судалгаанд неореализм, довтолгооны реализм, зүрхэн газар зэрэг онолуудыг харьцуулан тайлбарлах онолын шинжилгээ, Орос-Украины дайны дараах Евразийн тээврийн коридоруудын өөрчлөлтийг кейс судалгааны аргаар үнэлэх аргыг ашиглав. Мөн OECD, World Bank, European Commission, TITR зэрэг байгууллагын 2022-2025 оны статистик мэдээллийг баримт бичгийн шинжилгээний хүрээнд ашиглав.

Онол, үүссэн нөхцөл байдлын уялдаа

Энэхүү өгүүлэлээр неореализм, довтолгооны реализм болон, зүрхэн газар зэрэг геополитикийн онолыг геоэдийн засгийн шинжилгээтэй нэгтгэн дүн шинжилгээ хийхийг хичээлээ. Энэ нь Орос-Украины дайныг зөвхөн цэрэг-улс төрийн мөргөлдөөн бус, Евразийн холболтын бүтэц, стратегийн дэд бүтэц, нийлүүлэлтийн сүлжээний дахин зохион байгуулалтаар тодорхойлогдох геоэдийн засгийн шилжилтийн үйл явц гэж тайлбарлах боломж олгож байна. Үүний үндсэн дээр бид өөрийн орны онцлогийг цаашид геоэдийн засгийн өнцгөөс үнэлэх хэрэгцээ шаардлага байгааг илэрхийлэхийг зорилоо.

1. Кеннит Валзийн неореализмын онол ба ба аюулгүй байдлын хоёрдмол байдал.

Кеннит Валзийн неореализмын онолын дагуу олон улсын харилцааны систем нь төвлөрсөн эрх мэдэлгүй, нэгдсэн засаглалгүй байдаг. Ийм нөхцөлд улс орнууд өөрийн оршин тогтнол, аюулгүй байдлыг хангахын тулд бие даасан шийдвэр гаргаж, стратегийн сонголт хийдэг (Waltz 1979). Гэвч энэ нь улс орнуудын хооронд хангалттай итгэлцлийг бий болгож чаддаггүй бөгөөд ямарваа нэг улсын аюулгүй байдлаа хангах зорилготой бодлого, институцийн тэлэлт нь нөгөө улсын хувьд заналхийлэл мэтээр ойлгогдох нөхцөлийг бүрдүүлдэг. Үүний үр дүнд аюулгүй байдлын хоёрдмол, зөрчилт байдлыг үүсгэдэг бөгөөд энэ нь нэг талдаа хамгаалалтын зорилготой үйлдэл ч эсрэг талдаа түрэмгий шинжтэй мэт ойлгогдох

системийн зөрчил юм.

Энэхүү онолын хүрээнд НАТО-гийн өргөжилтийг хоёр өөр геополитикийн өнцгөөс авч үзэх боломжтой. Барууныханы хандлагаар НАТО-гийн тэлэлт нь Хүйтэн дайны дараа Европт тогтвортой байдлыг хангах, хамтын хамгаалалтыг бэхжүүлэх зорилготой институцийн тэлэлт юм. Энэ утгаараа НАТО нь аюулгүй байдлыг “хамтын ажиллагаа ба дүрэмд суурилсан дэг журам”-аар хангах механизм гэж ойлгогддог.

Харин Оросын геополитикийн хандлагаар НАТО-гийн зүүн тийш өргөжилт нь оросын стратегийн орон зайд хэт ойртсон цэргийн эвслийн тэлэлт бөгөөд энэ нь Оросын нөлөөллийн бүс буюу аюулгүй байдлын орчинд эрсдэл учруулах, геостратегийн шахалт үүсгэж байна гэж үздэг (Mearsheimer 2014).

Ийнхүү Орос-Барууны аюулгүй байдлын ойлголтын зөрчил нь Валзийн неореализмын үндсэн санаа болох олон улсын системийн тодорхой бус байдал, харилцан үл итгэлцэл, өөртөө туслах зарчим (self-help principle) хэрхэн үйлчилж байгааг харуулдаг. Улс орнууд бусдын зорилгыг бүрэн тодорхойлох боломжгүй нөхцөлд тухайн улсын чадавх, газарзүйн байрлал, стратегийн үйл ажиллагаанд үндэслэн болзошгүй эрсдэлийг үнэлдэг. Үүний үр дүнд хамгаалалтын шинжтэй бодлого хүртэл өрсөлдөгчийн зүгээс довтолгооны шинжтэй гэж ойлгогдож, аюулгүй байдлын хоёрдмол байдлыг улам гүнзгийрүүлэх нөхцөл бүрддэг (Waltz 1979; Jervis 1978). Ийнхүү энэ зөрчил нь аюулгүй байдлын хоёрдмол байдлыг бий болгож буйг илтгэдэг байна.

2. Жон Ж. Миршаймерын довтолгооны реализмын онол ба бүс нутгийн ноёрхол

Жон Ж. Миршаймерын довтолгооны реализмын онол нь олон улсын тогтолцоо төвлөрсөн эрх мэдэлгүй, нэгдсэн засаглалгүй байдаг тул улс орнууд зөвхөн оршин тогтнох өөрийн стратегиар хязгаарлахгүй, өөрийгөө чадавхижуулах хүчин чадлыг тасралтгүй нэмэгдүүлж, бүс нутагтаа давамгайлах байр суурьтай байхыг эрмэлзэхэд хүргэдэг гэсэн үзэлд тулгуурладаг (Mearsheimer 2001). Өөрөөр хэлбэл их гүрнүүдийн аюулгүй байдал нь бие биеээс харьцангуй давуу байдал бий болгох замаар хангагддаг гэж үздэг байна. Довтолгооны реализмын үүднээс авч үзвэл их гүрнүүд өөрийн аюулгүй байдлын орчинд стратегийн өрсөлдөгч хүчний нөлөө нэмэгдэхийг боломжит аюул занал гэж хүлээн авч, түүнийг бууруулах, тэнцвэржүүлэх, эсвэл хязгаарлах бодлого хэрэгжүүлэх хандлагатай байдаг. Иймээс геополитикийн хувьд их гүрнүүдийн хооронд байрладаг улс орнууд нь зөвхөн тусгаар тогтносон субъект бус, харин хүчний тэнцвэрийн өрсөлдөөний стратегийн орон зай болон хувирдаг (Mearsheimer 2001; Waltz 1979).

Энэхүү онолын хүрээнд их гүрнүүд өөрийн стратегийн гэж тодорхойлогдох нөлөөний бүсэд бусад хүчний нөлөөлөл нэмэгдэхийг аюулгүй байдлын шууд эрсдэл гэж үзэж, түүнийг хязгаарлах эсвэл бууруулах чиглэлд бодлого хэрэгжүүлдэг. Нөгөө талаар газарзүйн хувьд их гүрнүүдийн дунд зааг болж байдаг улс орнууд нэг талаар их гүрнүүдийн хоорондын шууд тулгаралтыг сааруулах бүс буюу стратегийн хамгаалалтын үүргийг гүйцэтгэдэг гэж үздэг.

Энэхүү онолын хүрээнд Оросын стратегийн ойлголтоор Украин нь хэд хэдэн давхар геополитикийн үүрэгтэй орон зай гэж тайлбарлагдана. Үүнд:

- Баруун чиглэл дэх стратегийн хамгаалалтын бүс;
- НАТО болон Европын Холбооны тэлэлтийн боломжит геостратегийн гарц;
- Хар тэнгисийн бүсийн аюулгүй байдлыг тодорхойлох стратегийн зангилаа болдог байна ([Mearsheimer 2014, 2022](#)).

Дээрхээс үзэхэд Украиныг зөвхөн гадаад бодлогын объект бус, харин ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын архитектурын чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх нөхцөлийг бүрдүүлдэг. Иймээс Украин нь уламжлалт утгаар жижиг улс биш, харин их гүрнүүдийн стратегийн ашиг сонирхол огтлолцдог завсарын бүс болж байна. Үүнээс улбаалан Украин нь олон улсын системд зөвхөн завсарын бүсийн үүрэг гүйцэтгэгч бус их гүрнүүдийн ашиг сонирхол огтлолцдог, бүс нутгийн хүчний тэнцвэрт нөлөөлөх стратегийн ач холбогдолтой улс гэж тодорхойлогдож байна.

3. Халфорд Жон Маккиндерын Зүрхэн газрын онол: Евразийн геостратегийн тэнхлэг

Их Британийн газарзүйч, геополитикийн онолч Халфорд Жон Маккиндерын “Heartland Theory” буюу буюу Зүрхэн газрын онолоор геополитикийн хамгийн нөлөө бүхий онолуудын нэг бөгөөд дэлхийн хүчний төв нь далай бус, харин Евразийн эх газрын төв хэсэг бөгөөд энэ нь дэлхийн стратегийн хамгийн чухал геополитикийн орон зайд тооцогддог.

Учир нь энэ бүс нутаг байгалийн онцлогтой уялдсан өнгөлөн далдлалт, хамгаалалтын, далайд шууд гарах гарц хязгаарлагдмал тул гадаад нөлөөлөл, аюул заналд өртөх эрсдэл багатай байдаг учраас далайн хүчнүүдээс харьцангуй хараат бус, өөрөө өөрийгөө тэтгэх чадвартай эх газрын стратегийн чухал бүс болдог байна ([Mackinder 1904, 1919](#)).

Энэхүү онолын хүрээнд Украины геополитикийн байрлал нь онцгой стратегийн ач холбогдолтой бүс нутаг гэж тооцогддог. Тодруулбал, Украин нь:

- Евразийн төв болон харин түүнийг хүрээлсэн эрэг орчмын бүсийн зааг дээр байрлах шилжилтийн геостратегийн орон зай;
- Европ тив ба Евразийн эх газрын системийг холбосон геостратегийн гарц;
- ОХУ-ын баруун өмнөд чиглэлийн стратегийн гүн хамгаалалтын чухал бүрэлдэхүүн хэсэг болон тодорхойлогддог ([Mackinder 1904; Brzezinski 1997](#)).

Ийм нөхцөлд Украин нь зөвхөн газарзүйн нэгж улс бус, харин дэлхийн геополитикийн хоёр том стратегийн системийн огтлолцолд орших геостратегийн орон зай юм ([Brzezinski 1997](#)).

Эдгээр онолуудыг харьцуулан авч үзэхэд Украин нь уламжлалт ойлголтоор «жижиг улс» бус, харин их гүрнүүдийн стратегийн ашиг сонирхол огтлолцдог, бүс нутгийн болон олон улсын хүчний тэнцвэрт нөлөө үзүүлэх өндөр ач холбогдолтой геостратегийн орон зай болох нь тодорхой байна. Иймээс Украин дахь мөргөлдөөнийг зөвхөн цэрэг, улс төрийн өнцгөөс бус, олон улсын тогтолцооны бүтэц, геостратегийн байршил, аюулгүй байдлын динамик болон их гүрнүүдийн өрсөлдөөний харилцан хамаарлыг цогцоор нь авч үзэх шаардлагатай юм.

Гэвч энэхүү мөргөлдөөний үр нөлөө нь зөвхөн аюулгүй байдал, цэрэг-улс төрийн хүрээнд хязгаарлагдсангүй. XXI зууны олон улсын харилцаанд геополитикийн өрсөлдөөн нь улам бүр эдийн засгийн холболт, худалдааны урсгал,

эрчим хүчний нийлүүлэлт, тээврийн сүлжээ, технологийн хамаарал, хөрөнгө оруулалтын чиглэлээр илэрч байгаа тул Орос-Украины дайн нь Евразийн геоэдийн засгийн бүтцэд өөрчлөлт авчирсан байна. Өөрөөр хэлбэл, энэхүү дайн нь зөвхөн газар нутгийн болон аюулгүй байдлын асуудал бус, харин Евразийн эдийн засгийн холболт, нийлүүлэлтийн сүлжээ, стратегийн хамаарлын шинэ бүтцийг бий болгож буй системийн өөрчлөлтийн хүчин зүйл болж байгааг анхаарах ёстой юм.

Дайны геоэдийн засгийн зарим асуудалд

Орчин үеийн олон улсын харилцаанд тээвэр, ложистикийн сүлжээ нь зөвхөн эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих дэд бүтэц бус, харин улс орнуудын стратегийн бие даасан байдал, нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдал, геоэдийн засгийн өрсөлдөх чадварыг тодорхойлох чухал хүчин зүйл болж байна. Өмнө нь газарзүйн байршил, байгалийн нөөц, үйлдвэрлэлийн хүчин чадлыг эдийн засгийн хүчний үндсэн үзүүлэлт гэж үздэг байсан бол өнөөгийн нөхцөлд улс орнуудын дэлхийн эдийн засагт эзлэх байр суурь нь тэдгээрийг холбож буй тээврийн коридор, ложистикийн сүлжээ, худалдааны урсгалын хүртээмжээр улам бүр тодорхойлогдох болсон. Өөрөөр хэлбэл, стратегийн холболт нь ХХI зууны геоэдийн засгийн нөлөөллийн нэг гол хэрэгсэл болж байна ([Blackwill and Harris 2016](#)).

Орос-Украины дайн эхэлснээр Евразийн геополитикийн орчин зөвхөн аюулгүй байдал, цэрэг-улс төрийн хүрээнд бус, худалдаа, тээвэр, эрчим хүч, ложистик, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн сүлжээ зэрэг геоэдийн засгийн үндсэн бүтцүүдэд гүнзгий өөрчлөлт авчирлаа. Энэхүү өөрчлөлтийн үр дүнд Евразийн худалдааны уламжлалт урсгалууд өөрчлөгдөж, улс орнуудын стратегийн хамаарал шинэчлэгдэн, бүс нутгийн интеграцийн шинэ хэлбэрүүд бүрэлдэж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, Орос-Украины дайн нь Евразийн геоэдийн засгийн орон зайг өөрчлөх үйл явдлын нэг болж байна ([Blackwill and Harris 2016](#); [O.E.C.D. 2023b](#)). Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага ([O.E.C.D. 2023b](#))-ын судалгаагаар Орос-Украины дайны дараа Хойд тээврийн коридороор дамжих ачаа тээвэр эрс буурч, тээврийн урсгал Транскаспийн олон улсын тээврийн маршрут буюу Европын Холбоо-Хятадын хооронд ОХУ-аар дамжин тээвэрлэгддэг контейнерийн хэмжээ дор хаяж 35 хувиар буурсан гэж дурдсан бөгөөд энэ нь олон улсын ложистикийн компаниуд тээврийн маршрутаа төрөлжүүлэх бодлого хэрэгжүүлэхэд хүргэсэн гэж дүгнэжээ ([O.E.C.D. 2023a](#); [Arvis et al. 2023](#)).

Дайнаас өмнө Европ болон Зүүн Азийг холбосон төмөр замын тээврийн үндсэн чиглэл нь ОХУ, Беларусь, Польшийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг Хойд тээврийн коридор байв. Энэхүү коридор нь БНХАУ-ын «Бүс ба Зам» санаачилгын хамгийн хөгжсөн хуурай замын чиглэл болж, Европ-Азийн төмөр замын ачаа тээврийн дийлэнх хэсгийг дамжуулж байсан. Харин 2022 оноос эхлэн ОХУ-ын эсрэг хэрэгжүүлсэн эдийн засаг, санхүү, ложистикийн өргөн хүрээний хориг арга хэмжээ, даатгалын эрсдэлийн өсөлт, төлбөр тооцооны хүндрэл, геополитикийн тодорхойгүй байдлын улмаас энэхүү коридорын ашиглалт эрс буурч эхэлсэн ([O.E.C.D. 2023a](#); [European Bank for Reconstruction and Development 2023](#)).

Үүний зэрэгцээ Казахстан-Каспийн тэнгис-Азербайжан-Гүрж-Турк-Европ чиглэлээр хөгжиж буй Дунд коридор нь Евразийн худалдааны шинэ стратегийн

гол гарц болон эрчимтэй хөгжиж байна. Энэхүү коридор нь Хятад, Төв Ази, Өмнөд Кавказ болон Европыг холбох олон улсын төмөр зам, далайн болон авто тээврийн нэгдсэн сүлжээ бөгөөд Евразийн худалдааны эрсдэлийг төрөлжүүлэх, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, улс төрийн эрсдэлийг бууруулах стратегийн хэрэгсэл болж байна. Транскаспийн олон улсын тээврийн маршрут (Trans-Caspian International Transport Route, TITR) буюу Дунд коридорын ачаа тээврийн хэмжээ сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж байна. TITR-ийн мэдээллээр тус коридороор дамжин өнгөрсөн ачааны хэмжээ 2021 онд ойролцоогоор 1.8-2.0 сая тонн байсан бол 2024 онд 3.3 сая тоннд хүрч, өмнөх онтой харьцуулахад 20 хувиар өссөн байна. Энэ өсөлт нь Орос-Украины дайны дараах геополитикийн эрсдэлийн улмаас Хойд тээврийн коридороос бусад маршрутууд руу ачааны урсгал шилжиж буй үйл явцтай холбоотой юм.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын үнэлгээгээр Дунд коридор нь одоогоор Хойд коридорын хүчин чадлын багахан хэсгийг эзэлж байгаа боловч дэд бүтцийн шинэчлэл, боомтын хүчин чадлын өргөтгөл, төмөр замын холболт, хил гаалийн үйл ажиллагааны уялдаа сайжирсан тохиолдолд Евразийн стратегийн хэмжээний тээврийн маршрут болох боломжтой байна. Казахстан, Азербайжан, Гүрж, Турк зэрэг орнуудын хамтын ажиллагааны хүрээнд боловсруулсан хөгжлийн төлөвлөгөөнүүдэд тус коридорын хүчин чадлыг 2025-2030 оны хугацаанд жилд 10 сая тонн хүртэл нэмэгдүүлэх зорилт тусгагдсан байна (O.E.C.D. 2023a).

Дунд коридор нь богино хугацаанд Хойд тээврийн коридорыг бүрэн орлох боломжгүй боловч Евразийн нийлүүлэлтийн сүлжээнд хоёр дахь стратегийн логиستيкийн тэнхлэг болон төлөвшиж, Европ-Ази хоорондын худалдааны урсгалын төрөлжилт, бүс нутгийн эдийн засгийн интеграц, геоэдийн засгийн тэнцвэрийн шинэ бүтэц бүрэлдэхэд чухал нөлөө үзүүлж байна. OECD-ийн дүгнэснээр Дунд коридорыг зөвхөн транзит маршрут бус, Төв Ази, Өмнөд Кавказын бүс нутгийн эдийн засгийн интеграцын хөдөлгөгч хүчин болгон хөгжүүлэх шаардлагатай юм (O.E.C.D. 2023a; Arvis et al. 2023). Гэсэн хэдий ч Дунд коридорын хөгжилд хэд хэдэн бүтцийн сорилт хэвээр байна. Үүнд Каспийн тэнгисийн боомтын багтаамж, төмөр замын царигийн ялгаа, гаалийн журмын уялдаа хангалтгүй байдал, тээврийн дижитал удирдлагын сул хөгжил, далайн тээврийн хүчин чадлын хязгаарлалт зэрэг асуудал багтаж байна. Иймээс энэхүү коридорын өрсөлдөх чадвар нь зөвхөн дэд бүтцийн хөрөнгө оруулалтаас бус институцийн шинэчлэл, хил дамнасан зохицуулалт, гаалийн үйл ажиллагааны цахим шилжилтээс ихээхэн хамаарах болсон.

Европын Холбоо энэхүү өөрчлөлтийг стратегийн түвшинд үнэлж, “Олон улсын гарц”, санаачилгын хүрээнд Төв Ази болон Өмнөд Кавказын дэд бүтэц, эрчим хүч, дижитал сүлжээ, стратегийн ашигт малтмалын нийлүүлэлтийн тогтолцоонд олон тэрбум еврогийн хөрөнгө оруулалт хийх бодлого хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь Европын Холбоо Евразийн холболтын асуудлыг зөвхөн эдийн засгийн бус, стратегийн бие даасан геоэдийн засгийн өрсөлдөөний хүрээнд авч үзэж байгааг харуулж байна.

Нөгөө талаас БНХАУ энэхүү нөхцөл байдлыг «Бүс ба Зам» санаачилгын шинэ үе шаттай уялдуулан ашиглаж, Төв Ази, Каспийн бүс, Өмнөд Кавказын орнуудтай

эдийн засаг, тээвэр, эрчим хүчний хамтын ажиллагаагаа эрчимжүүлж байна. Энэ нь зөвхөн Европын зах зээлд хүрэх нэмэлт гарцыг бий болгохоос гадна Малаккийн хоолой болон Энэтхэг-Номхон далайн бүс дэх далайн тээврийн эрсдэлийг бууруулах стратегийн ач холбогдолтой гэж БНХАУ үзэж байна (N.D.R.C. 2015; Rolland 2017). Үүний үр дүнд Казахстан, Азербайжан, Гүрж, Турк зэрэг улсууд Евразийн худалдааны шинэ зангилаа болон хувирч, тус бүс нутгийн геополитикийн хувьд хамгийн чухал бүс нутаг болох нь тодорхой байна.

Эдгээр үйл явц нь Евразийн интеграцийн уламжлалт ойлголтыг өөрчлөх нөхцөлийг бүрдүүлж байна. Өмнө нь Евразийн орон зайд тодорхой нэг хүчний төв давамгайлсан, харьцангуй нэг чиглэлтэй интеграцийн хандлага ажиглагдаж байсан бол өнөөгийн нөхцөлд олон төрлийн интеграцийн төсөл, холболтын стратегиуд нэгэн зэрэг хэрэгжиж, тус геостратегийн орон зайд харилцан нөлөөлөх, өрсөлдөх шинжтэй болж байна. Үүний үр дүнд Евразийн интеграц нь нэг төвт загвараас олон төвт, өрсөлдөөнт, давхардсан ашиг сонирхол бүхий шинэ бүтэц рүү шилжиж байна гэж дүгнэж болно.

Энэхүү өөрчлөлт нь XXI зууны геополитикийн хүчний тэнцвэрийг зөвхөн цэрэг, улс төрийн хүчин чадлаар хэмжих боломжгүй болсныг харуулж байна. Орчин үеийн стратегийн өрсөлдөөн нь худалдааны урсгал, эрчим хүчний аюулгүй байдал, тээврийн холболт, стратегийн ашигт малтмалын хүртээмж, хөрөнгө оруулалтын чиглэл, технологийн болон дижитал дэд бүтцийн хяналт зэрэг геоэдийн засгийн хүчин зүйлсээр улам бүр тодорхойлогдох болсон байна. Энэ хүрээнд Дунд коридорын хөгжил нь зөвхөн Европ-Ази хоорондын тээврийн шинэ чиглэл бий болж буй үйл явц бус, харин Евразийн эдийн засгийн холболтын шинэ бүтэц бүрэлдэж байгааг илэрхийлж байна. Энэхүү өөрчлөлт нь газарзүйн хувьд ОХУ, БНХАУ-ын хооронд орших Монгол Улсын хувьд стратегийн орчныг дахин үнэлэх шаардлагыг бий болгож байна. Өөрөөр хэлбэл, Евразийн тээвэр, худалдааны урсгалын чиглэл өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд Монгол Улс зөвхөн байгалийн нөөц экспортлогч улс бус, бүс нутгийн холболтын идэвхтэй оролцогч, стратегийн тээвэр, логистикийн зангилаа болох боломжоо ашиглах шаардлагатай болж байна.

Монгол Улсын геоэдийн засгийн шинэ боломжийн талаарх зураглал

Үндэсний аюулгүй байдлыг хангах хамгийн бат бөх суурь нь зөвхөн улс төрийн тэнцвэрээр хязгаарлагдахгүй, эдийн засгийн тогтвортой байдал, олон талт худалдааны харилцаа, найдвартай дэд бүтэц, технологийн чадавх, гадаад хамаарлыг бууруулах сөрөн тэсвэрлэх чадварт оршдог. Иймээс бид өөрийн газарзүйн байрлал, байгалийн баялаг, хүний нөөц, стратегийн байршлыг ашиглан ямарч нөхцөлд өөртөө давуу талыг бий болгож чаддаг улс болох шаардлагатай байна.

Евразийн геоэдийн засгийн орчны өөрчлөлт нь Монгол Улсын хувьд зөвхөн гадаад орчны хувьсал төдий бус, харин үндэсний хөгжлийн загвар, эдийн засгийн аюулгүй байдал, бүс нутгийн холболтын стратегиа дахин тодорхойлох шаардлагатай болсон стратегийн шинэ нөхцөл байдлыг бий болгож байна. Евразийн худалдаа, тээврийн сүлжээний дахин зохион байгуулалт нь газарзүйн байрлалын хувьд их гүрнүүдийн дунд орших онцлогтой бид геоэдийн засгийн ач холбогдлыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж байна. Тиймээс дараах чиглэлд бид анхаарах нэн чухал хэрэгцээ, шаардлага гарч байна. Үүнд;

Нэгдүгээрт, Монгол Улс Евразийн шинэ эдийн засгийн тогтолцоонд өөрийн стратегийн байр суурийг тодорхойлсон цогц холболтын бодлого боловсруулах шаардлагатай байна. Өмнө нь Монгол Улсын транзит тээврийн чиглэл үндсэндээ Орос-Хятадыг холбосон уламжлалт хойд-өмнөд тэнхлэгт төвлөрч байсан бол өнөөгийн геоэдийн засгийн өөрчлөлт нь Монгол Улсад бүс нутгийн нийлүүлэлтийн сүлжээний илүү өргөн хүрээний оролцогч болох боломжийг нээж байна. Иймээс Монголын тээврийн коридоруудыг зөвхөн хоёр хөршийн зах зээлтэй холбох бус, Төв Ази, Каспийн бүс, Европын холболтын өргөн сүлжээтэй уялдуулах стратеги шаардлагатай болж байна. Өөрөөр хэлбэл Дунд коридорын хөгжил, Төв Ази-Каспийн бүсийн холболтын өсөлт нь Монгол Улсыг зөвхөн дамжин өнгөрөх улс бус, Евразийн нийлүүлэлтийн сүлжээний идэвхтэй оролцогч болох боломжийг нээж байна.

Хоёрдугаарт, Монгол Улс тээврийн дэд бүтцийг зөвхөн экспортын бүтээгдэхүүн гаргах хэрэгсэл бус, үндэсний геоэдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх стратегийн хөрөнгө гэж үзэх шаардлагатай. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортод өндөр хамааралтай эдийн засгийн бүтэц нь гадаад зах зээлийн хэлбэлзэл, нийлүүлэлтийн эрсдэлд эмзэг байдлыг бий болгож байна. Ийм нөхцөлд төмөр зам, авто зам, логистикийн төв, хуурай боомт, хил гаалийн дижитал систем зэрэг дэд бүтцийн хөгжлийг эдийн засгийн төрөлжилт, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын нэг хэсэг болгон авч үзэн хөгжүүлэх шаардлагатай. Тухайлбал бид чухал шаардлагатай хилийн боомтуудыг олон улсын логистикийн зангилаа болгон хөгжүүлэх замаар бүс нутгийн нийлүүлэлтийн сүлжээнд илүү өндөр нэмүү өртөг бүхий байр суурь эзлэх боломжтой.

Гуравдугаарт, Монгол Улс “гуравдагч хөрш”-ийн бодлогын агуулгыг геоэдийн засгийн шинэ нөхцөлд өргөжүүлэх шаардлагатай байна. Өнөөгийн олон төвт олон улсын орчинд стратегийн тэнцвэрийг хадгалах нь зөвхөн дипломат харилцааны асуудал бус, хөрөнгө оруулалт, технологийн хамтын ажиллагаа, дэд бүтцийн хөгжлийн бодлоготой салшгүй холбоотой болж байна. Иймээс Монгол Улс олон улсын түншүүдтэй хамтран ажиллахдаа бүс нутгийн тогтвортой холболтыг дэмжигч, найдвартай, нээлттэй эдийн засгийн түнш гэсэн байр суурийг бэхжүүлэх шаардлагатай. Тухайлбал Европын Холбооны «Олон улсын гарц», Японы чанартай дэд бүтцийн түншлэл, БНСУ-ын шинэчилсэн Төв Азийн хамтын ажиллагааны бодлого зэрэг санаачилгуудтай уялдах нь зөвхөн хөрөнгө оруулалтын эх үүсвэр нэмэгдүүлээд зогсохгүй, стратегийн тэнцвэрийг хадгалах боломж олгоно.

Дөрөвдүгээрт, Евразийн шинэ тээврийн коридоруудын өрсөлдөөнд Монгол Улс зөвхөн газарзүйн байрлалын давуу талд найдах боломжгүй болсон байна. Орчин үеийн логистикийн өрсөлдөх чадвар нь зөвхөн физик дэд бүтцээс гадна институцийн үр ашиг, хил гаалийн зохицуулалт, мэдээллийн нэгдсэн систем, технологийн инновац, үйлчилгээний чанараар тодорхойлогдож байна. Иймээс Монгол Улс “ухаалаг хил”, дижитал логистик, өгөгдөлд суурилсан тээврийн удирдлага, шинэ үеийн технологийн шийдлүүдийг үндэсний холболтын бодлогын салшгүй хэсэг болгон хөгжүүлэх шаардлагатай.

Тавдугаарт, Евразийн геоэдийн засгийн өөрчлөлтийг Монгол Улс үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, тэр дундаа эдийн засгийн сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх стратегийн боломж гэж үзэх шаардлагатай. Гадаад худалдаа, экспортын

бүтцийн өндөр төвлөрөл нь эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байгаа нөхцөлд шинэ тээврийн чиглэл, олон талт эдийн засгийн холболт, нийлүүлэлтийн сүлжээний төрөлжилт нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах чухал механизм болж чадна. Өөрөөр хэлбэл, тээврийн коридорын хөгжил нь зөвхөн эдийн засгийн өсөлтийн асуудал бус, стратегийн бие даасан байдал, үндэсний тогтвортой байдлыг хангах хүчин зүйл юм.

Иймээс Монгол Улсын хувьд Евразийн геоэдийн засгийн шинэ нөхцөлд “дамжин өнгөрөх улс” гэсэн уламжлалт ойлголтоос татгалзаж, “бүс нутгийн холболтын стратегийн зангилаа улс” болох зорилгод чиглэх шаардлагатай байна. Үүний тулд Монгол Улс үндэсний тээврийн коридоруудаа олон улсын сүлжээнд үр ашигтай холбох, олон талт хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэх, логистикийн чадавхыг технологийн шинэчлэлээр нэмэгдүүлэх, цаашид Евразийн шинэ бүтцэд өөрийн байр суурийг тодорхойлох гол нөхцөл болно.

Дүгнэлт

Орос-Украины дайнаас үүдэлтэй олон улсын харилцаа, аюулгүй байдлын орчны өөрчлөлт нь Монгол Улс шиг далайд гарцгүй, хоёр их гүрний дунд орших улсын хувьд олон улсын харилцааны онолын аль нэг чиглэлийг дангаар баримтлах бус, өөрийн геополитикийн онцлогт нийцсэн цогц стратегийн ойлголт шаардлагатайг харуулж байна. Бидний хувьд хөгжлийн философи нь реализм, неореализм, геоэдийн засгийн хандлага, жижиг улсын стратегийн онол зэргийг уялдуулан авч үзэх нь илүү тохиромжтой гэж үзэж болох юм. Тухайлан дараахыг дурдаж болно. Үүнд:

Нэгдүгээрт, неореализмын онолын үүднээс Монгол Улс олон улсын системийн анархик бүтцэд өөрийн аюулгүй байдлыг аливаа гаднын баталгаанд бүрэн найдах боломжгүй бөгөөд үндэсний чадавх, стратегийн сөрөн тэсвэрлэх чадвараа тасралтгүй бэхжүүлэх шаардлагатай. Хоёр их гүрний дунд орших нөхцөл нь Монгол Улсыг хүчний тэнцвэрийн өөрчлөлтөд мэдрэмтгий болгож байгаа тул үндэсний аюулгүй байдлыг олон талт хэмжүүрээр тухайлан эдийн засаг, эрчим хүч, хүнс, технологи, нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлыг хангах тогтолцоог бий болгох шаардлагатайг харуулж байна.

Хоёрдугаарт, аюулгүй байдлын хоёрдмол байдлын онолын үүднээс хөрш орнуудын стратегийн бодлогыг анхааралтай ажиглаж харилцан итгэлцэл, тэнцвэртэй харилцааг хадгалах дипломат механизмыг хөгжүүлэхийн зэрэгцээ стратегийн бие даасан байдлыг нэмэгдүүлэхэд анхаарч “гуравдагч хөрш”-ийн бодлогыг зөвхөн улс төрийн түншлэл бус, технологи, хөрөнгө оруулалт, дэд бүтэц, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих геоэдийн засгийн стратеги болгон өргөжүүлэхийг чухалчилан авч үзэх хэрэгтэй.

Гуравдугаарт, геоэдийн засгийн хандлагаас авч үзвэл газарзүйн байршлийн онцлог байдлаа эдийн засгийн давуу тал болгон хувиргах явдал юм. Евразийн тээврийн коридоруудын дахин бүтэцжилт, Дунд коридорын хөгжил, нийлүүлэлтийн сүлжээний өөрчлөлт нь Монгол Улсад зөвхөн транзит улсын байр сууринаас хальж, бүс нутгийн холболтын зангилаа болох боломжийг бий болгож байна. Иймээс тээвэр, логистик, дижитал дэд бүтэц, стратегийн ашигт малтмал, эрчим хүчний салбарыг эрчимтэй хөгжүүлэх зэрэг болно.

Иймээс бид өөрийн газарзүйн байрлал, эдийн засгийн боломж, олон талт дипломат харилцааг ашиглан үндэсний ашиг сонирхлоо хамгаалах хөгжлийн тохиромжтой онолын суурь нь «стратегийн бие даасан байдалд тулгуурласан реалист-геоэдийн засгийн хандлага» гэж тодорхойлж болох юм.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Arvis, Jean-François, Lauri Ojala, Ben Shepherd, Daria Ulybina, and Christina Wiederer. 2023. *Connecting to Compete 2023: Trade Logistics in an Uncertain Global Economy - The Logistics Performance Index and Its Indicators*. World Bank Publications - Reports No. 39760. The World Bank Group. <https://doi.org/None>.
2. Blackwill, R. D., and J. M. Harris. 2016. *War by Other Means: Geoeconomics and Statecraft*. Harvard University Press.
3. Brzezinski, Zbigniew K. 1997. “A Geostrategy for Eurasia.” *Foreign Affairs* 76: 50. <https://api.semanticscholar.org/CorpusID:157407724>.
4. European Bank for Reconstruction and Development. 2023. *Regional Connectivity and Infrastructure Development in Central Asia*. EBRD.
5. Jervis, Robert. 1978. “Cooperation Under the Security Dilemma.” *World Politics* 30 (2): 167-214. JSTOR. <https://doi.org/10.2307/2009958>.
6. Mackinder, H. J. 1904. “The Geographical Pivot of History.” *The Geographical Journal* 23 (4): 421-37. JSTOR. <https://doi.org/10.2307/1775498>.
7. Mackinder, H. J. 1919. *Democratic Ideals and Reality; a Study in the Politics of Reconstruction*. New York.
8. Mearsheimer, J. J. 2001. *The Tragedy of Great Power Politics*. W.W. Norton & Company.
9. Mearsheimer, J. J. 2014. *The Tragedy of Great Power Politics*. (Updated Edition). W.W. Norton & Company.
10. Mearsheimer, J. J. 2022. “Playing with Fire in Ukraine: The Underappreciated Risks of Catastrophic Escalation.” *Foreign Affairs*, August 17.
11. N.D.R.C. 2015. *Vision and Actions on Jointly Building Silk Road Economic Belt and 21st-Century Maritime Silk Road*. Report of National Development and Reform Commission, People’s Republic of China.
12. O.E.C.D. 2023a. *OECD Economic Outlook*. Vol. 2023. no. ue 1. OECD Publishing. <https://doi.org/10.1787/ce188438-en>.
13. O.E.C.D. 2023b. *Realising the Potential of the Middle Corridor*. OECD Publishing. <https://doi.org/10.1787/635ad854-en>.
14. Rolland, Nadège. 2017. *China’s Eurasian Century? Political and Strategic Implications of the Belt and Road Initiative*. The National Bureau of Asian Research.
15. Waltz, K. N. 1979. *Theory of International Politics*. Addison-Wesley Series in Political Science, ISBN 978-0-07-554852-2.